

qPay ГАРЫН АВЛАГА

“QPAY” ГЭЖ ЮУ ВЭ?

Most Money хэтэвч QR-код ашиглан төлбөр хийх зориулалтын банк дундын qPay үйлчилгээнд нэгдэн орлоо. Ингэснээр Most Money ба qPay нэгдсэн нэг стандартын QR код ашиглан төлбөр төлөх, өөрийн дансандаа QR код болон нэхэмжлэх үүсгэж орлого хүлээн авах боломжтой боллоо.

ЯАГААД “QPAY”-Г АШИГЛАХ ВЭ?


- Дансны дугаар бичих шаардлагагүй
Гүйлгээний мэдээллийг нэг бүрчлэн бичих шаардлагагүй тул данс, мөнгөн дүн бусад мэдээлэл буруу оруулах эрсдэлгүй
- QR код бүхий таних тэмдэгтэй бүх газруудад банк үл харгалзан төлбөрөө төлөх боломжтой

АПЛИКЕЙШН СУУЛГАХ


Most Money аппликейшнийг Play store/Android/, Apple store /iOS/-аас гар утсандаа татаж суулгана. *Хэрэв Most Money аппликейшнтай бол 'Update' хийж шинэчилснээр 'qPay' меню шинээр нэмэгдэнэ.

QPAY МЕНЮНЫ БҮТЭЦ

1. НЭВТРЭХ



Most Money аппликейшнд нэвтрэлгүйгээр qPay менюг ашиглах



Нэвтрэх нэр, гар утасны дугаар, ПИН кодоо оруулах ММ апп-д нэвтрэнэ.

2. QR УНШИХ

Гар утасны камерыг ашиглах QR код уншигч гарч ирнэ. Энд QR кодыг шууд уншуулж эсвэл гар утсанд хадгалагдсан зургийг уншуулж төлбөр төлөх, мөнгө шилжүүлэх боломжтой. Жишээ нь QR код бүхий таних тэмдэгтэй бүх газруудад банк үл харгалзан төлбөрөө төлөх гэх мэт.

3. QR ЛАВЛАХ

qPay менюгээр хийгдсэн болон ирээдүйд хийхээр хадгалсан төлбөрийн түүхүүд харагдана.


4. QR ҮҮСГЭХ

Өөрийн дансанд QR код бүхий нэхэмжлэл үүсгэж бусдаас төлбөр цуглуулах боломжтой.


ХЭРХЭН ГҮЙЛГЭЭ ХИЙХ ВЭ?

A. ҮҮСГЭСЭН QR КОДЫН ДАГУУ БУСАД РУУ ШИЛЖҮҮЛЭГ ХИЙХ


1. QR унших менюг сонгоно.
2. Хэрэв MM апп-д нэвтрээгүй бол Нэвтрэх нэр, гар утасны дугаараа оруулан MM апп-д нэвтрэнэ.




3. Нэхэмжлэгчийн илгээсэн QR кодын зургийг 'QR унших' дэд менюг сонгон гар утаснаасаа уншуулна.



4. Нэхэмжлэгчийн QR кодыг уншуулснаар дэлгэц харагдана. Мэдээллийг баталгаажуулсны дараа "Үргэлжлүүлэх" товчийг дарна.




- Мэдээллээ шалгаад гүйлгнээ хийх товчийг дарна.




- Гүйлгээ амжилттай хийгдсэн эсэх мэдээлэл гарч ирнэ.
- Төлбөрийн түүх цэсийг сонгон төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллээ харна.

Б. QR КОД ҮҮСГЭЖ ОРЛОГО ХҮЛЭЭН АВАХ


- QR үүсгэх дэд менюг сонгоно.
- Хэрэв MM апп-д нэвтрээгүй бол нэвтрэх нэр, гар утасны дугаар, ПИН кодоо оруулж нэвтрэнэ.




- + товчийг дарна.



4. Өөрийн дансанд болон бусдын дансанд орлого хүлээн авах QR үүсгэх боломжтой бөгөөд хүлээн авах данс хэсэгт орлого хүлээн авах дансаа сонгоно.



Өөрийн дансанд QR нэхэмжлэх үүсгэх



Бусдын дансанд QR нэхэмжлэх үүсгэх

5. Дүнг оруулж QR үүсгэх товчийг дарахад оруулсан мэдээллийн дагуу нэхэмжлэх QR код үүснэ.
 6. Үүсгэсэн QR кодоо бусад руу илгээх эсвэл устгах боломжтой. Бусад руу илгээх суваг нь бүх төрлийн мэйл, мессэнжэр байх боломжтой.

